

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН  
2014 ОНЫ ХОЁРДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2014.8.07

Улаанбаатар хот

**НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 66 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 3 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 326 ББСБ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

2006 оны жилийн эцсийн тайлант хугацаанаас хойш ББСБ-уудын тоонд дараах өөрчлөлт орсон байна.

/Хүснэгт 1/

№	Тайлант хугацаа	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо	Үүнээс:		
			Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ	Зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлж буй ББСБ
1	2006 он	139	-	-	-
2	2007 он	137	-	-	-
3	2008 он	132	23	11	-
4	2009 он	177	27	9	47
5	2010 он	182	26	15	48
6	2011 он	195	23	17	39
7	2012 он	212	24	17	38
8	2013 он	263	31	19	41
9	2014 оны 2 улирал	326	37	23	50

Хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын асуудлуудыг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 2/

№	Тайлант хугацаа	Тусгай зөвшөөрөл шинээр олгосон	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн	Тусгай зөвшөөрлийг сэргээсэн	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо
1	2006 он	2	24	-	-	139
2	2007 он	10	12	-	-	137
3	2008 он	10	15	-	-	132
4	2009 он	56	11	15	9	177
5	2010 он	20	15	20	7	182
6	2011 он	32	19	14	8	195
7	2012 он	23	6	4	2	212
8	2013 он	54	3	3	1	263
9	2014 оны 2 улирал	66	3	4	-	326

2014 оны хоёрдугаар улиралд 66 компанид нийт 22,640,456.9 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон.

Тайлант улиралд Дорноговь, Булган, Өмнөговь аймагт тус бүр 1 ББСБ, Төв аймагт 2, Сэлэнгэ аймагт 2 ББСБ тус бүр 50.0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр, Улаанбаатар хотод 59 ББСБ 100.0-1,000.0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр зээл, гадаад валютын арилжаа, факторинг, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна.

2014 оны хоёрдугаар улиралд Хорооны хуралдаанаар 4 ББСБ-уудын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 3 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгон, 5 ББСБ-д тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны төрлийг нэмж олгосон.

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тооны өөрчлөлтийг графикаар үзүүлбэл:

/График 1/



ББСБ-уудыг Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж буйгаар нь ангилвал:

/Хүснэгт 3/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо	
		2014 оны I улирал	2014 оны II улирал
1	Гадаад валютын арилжаа эрхэлдэг нийт	111	118
	Үүнээс: зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг	44	50
2	Зээл	242	274
3	Факторингийн үйлчилгээ	15	16
4	Төлбөрийн баталгаа гаргах	10	11
5	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	0
6	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	5	6
7	Итгэлцлийн үйлчилгээ	21	23
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	2
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	23	25

2014 оны хоёрдугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 326 ББСБ-ын 84.0 хувь нь зээл, 36.2 хувь нь гадаад валютын арилжаа /15.3 хувь нь гадаад валютын

арилжааг дагнан эрхэлдэг/, 7.7 хувь нь хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 1.8 хувь нь цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 4.9 хувь нь факторингийн үйлчилгээ, 3.4 хувь нь төлбөрийн баталгаа гаргах, 7.1 хувь нь итгэлцлийн үйлчилгээ, 0.6 хувь нь богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхлэн явуулж байна.

2014 оны хоёрдугаар улирлын тайлан ирүүлбэл зохих нийт 326 ББСБ-аас 323 ББСБ буюу 99.1 хувь нь тайлангаа ирүүлснийг холбогдох журмын дагуу хянан тайлангийн нэгтгэлд хамруулсан болно.

## ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

### 2.1. Ерөнхий статистик үзүүлэлтүүд:

Өмнөх оны мөн үеийн голлох статистик үзүүлэлтүүдийг 2014 оны нэгдүгээр улирлын тайлант хугацаатай харьцуулж харуулбал: Үүнд

№	Үндсэн үзүүлэлтүүд	2013 оны II улирал	2014 оны II улирал	Өсөлт +/-, бууралт -/-
1	ББСБ-ын тоо	233.0	326.0	93.0
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	617.0	768.0	151.0
3	Ажиллагсадын тоо	1,292.0	1,632.0	340.0
4	Салбар нэгжийн тоо	69.0	89.0	20.0
5	Харилцагчдын тоо	394,666.0	471,090.0	76,424.0
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	307,736,217.0	443,530,955.5	135,794,738.5
	<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>	<i>1.93%</i>	<i>1.9%</i>	<i>0.2%</i>
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	188,120,936.3	270,357,033.0	82,236,096.7
	<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>	<i>2.17%</i>	<i>2.2%</i>	<i>0.0%</i>
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	198,714,723.9	279,465,509.1	80,750,785.2
	<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>	<i>17.43%</i>	<i>17.4%</i>	<i>-1.8%</i>
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	160,984,853.6	221,865,334.5	60,880,480.9
	<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>	<i>44.98%</i>	<i>58.7%</i>	<i>13.7%</i>
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	17,852,496.9	24,333,744.8	6,481,247.9
11	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/	63,522,781.9	113,733,652.5	50,210,870.6
	Үүнээс: Богино хугацаат зээл/мянган төгрөгөөр/	42,860,936.8	65,019,782.4	22,158,845.6
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	20,661,845.2	48,713,870.1	28,052,024.9
12	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	9,559,052.2	12,525,716.0	2,966,663.8
13	Нийт орлого /мянган төгрөгөөр/	37,965,607.3	63,564,369.2	25,598,761.9
14	Нийт зардал /мянган төгрөгөөр/	25,002,368.6	47,591,551.7	22,589,183.1
15	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	12,963,238.7	15,972,817.6	3,009,578.9

2014 оны хоёрдугаар улирлын байдлаар ББСБ-уудын нийт актив өмнөх оны мөн үеэс 44.1 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлтөд хувь нийлүүлсэн хөрөнгө 60.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Тухайлвал тайлант хугацаанд шинээр тусгай зөвшөөрөл авсан 66 ББСБ-ын нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 22.6 тэрбум төгрөг, тайлант хугацаанаас өмнө тусгай зөвшөөрөлтэй байсан ББСБ-ууд нийт 19.3 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүндээ өөрчлөлт оруулсан буюу нэмэлт хөрөнгө оруулалт, хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлсэн байна.

Тайлант хугацаанд ББСБ-уудын нийт актив 443.5 тэрбум төгрөг, зээлийн өрийн үлдэгдэл 270.4 тэрбум төгрөг, эзэмшигчдийн өмч 279.5 тэрбум төгрөг, дүрмийн сан 222.0 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын үзүүлэлтүүдтэй харьцуулахад нийт активын 1.9 хувьтай, зээлийн өрийн үлдэгдэл 2.2 хувьтай, эзэмшигчдийн өмчийн 17.4 хувьтай, дүрмийн сангийн 58.7 хувьтай тус тус тэнцэж байна. ББСБ-д ажиллах боловсон хүчний тоо 1,632, харилцагчдын тоо 471,090–д хүрсэн байна.

2014 оны хоёрдугаар улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөлтэй 326 ББСБ байгаагийн 88.7 хувь буюу 289 ББСБ нь УБ хотод, 11.4 хувь буюу 37 ББСБ нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

ББСБ-уудын байршлыг графикаар үзүүлбэл:

/график 2/



**2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:**

2014 оны хоёрдугаар улирлын байдлаар орон нутагт төвтэй 37 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 11.4 хувийг, тэдгээрийн актив нь нийт ББСБ-ын активын 2.0 хувийг, олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив нь нийт ББСБ-ын зээлийн үлдэгдлийн 2.6 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 3.0 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 2.7 хувийг тус тус эзэлж байна. Үүнд:

/Хүснэгт 5/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2013 оны II улирал	2014 оны II улирал	Өсөлт /+/, бууралт /-/
	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	25	37	12
	ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	10.73%	11,3%	3,7%
A	Нийт актив /мянган төгрөгөөр/	6 593 823,0	8 838 250,9	2,244,427.9
	ББСБ-ын нийт активт эзлэх хувь	2.14%	2,0%	0,5%
B	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	5 212 788,6	7 017 965,1	1,805,176.5
	ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	2.77%	2,6%	0,7%
	Чанаргүй зээл /мянган төгрөгөөр/	141 457,9	146 234,5	4,776.60
B	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	6 034 670,2	8 411 098,8	2,376,428.6
	ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь	3.04%	3,0%	0.9%

Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	4 420 761,8	6 060 951,8	1,640,190.0
	<i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i>	<i>2.75%</i>	<i>2,7%</i>	<i>0.7%</i>

Хорооноос орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бичил санхүүгийн байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх ажлын хүрээнд орон нутагт үйл ажиллагаа явуулах ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг ялгавартай тогтооон хэдий ч орон нутагт бичил санхүүгийн үйлчилгээний ач тусын талаар ойлголт муу, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээлэл, сурталчилгаа хангалтгүй байгаагаас өсөлтийн түвшин бага байна.

### **2.3 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:**

2014 оны хоёрдугаар улирлын байдлаар гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 24 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 7.4 хувийг, тэдгээрийн нийт актив ББСБ-ын нийт активын 14.3 хувийг, олгосон зээл нь нийт ББСБ-уудын олгосон зээлийн 14.7 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчдийн өмчийн 13.3 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 13.5 хувийг тус тус эзэлж байна.

/Хүснэгт 6/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2013 оны II улирал	2014 оны II улирал	Өсөлт +/-, бууралт -/-
	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	18	23	+5
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	<i>7.73%</i>	<i>7.1%</i>	<i>1.5%</i>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	48,018,726.0	63,204,412.1	14,647,417.1
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	<i>15.6%</i>	<i>14.3%</i>	<i>3.3%</i>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	31,668,633.6	39,804,676.3	8,136,042.7
	Үүнээс: Чанаргүй зээл /мянган төгрөгөөр/	2,451,069.3	2,335,493.9	-115,575.4
	<i>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>16.8%</i>	<i>14.7%</i>	<i>3.0%</i>
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	30,445,059.9	37,191,263.1	6,746,203.2
	<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>	<i>15.3%</i>	<i>13.3%</i>	<i>2.4%</i>
Г	Нийт дүрмийн сан /мянган төгрөгөөр/	24,300,362.50	29,910,829.4	5,610,466.9
	<i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i>	<i>15.1%</i>	<i>13.5%</i>	<i>2.3%</i>

Гадаадын хөрөнгө оруулагчдыг харьяаллаар нь авч үзвэл Япон улсын хөрөнгө оруулалттай 11, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 6, АНУ, Итали, ОХУ, БНХАУ, Люксембург, Малайз, Швейцарийн хөрөнгө оруулалттай тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

### **2.4 Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ББСБ:**

Тайлант хугацаанд буюу 2014 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт 66 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгосноос 12.1 хувь буюу 8 ББСБ-д банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон.

Хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 326 ББСБ-ын 118 ББСБ буюу 36.2 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгаагаас 50 ББСБ нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Тайлант хугацаанд гадаад валютын арилжааны үйл ажиллагааг давхар эрхлэн явуулж буй 118 ББСБ нь нийт ББСБ-ын 36.2 хувийг, тэдгээр нь 231,965,956.0 мянган төгрөгийн актив хөрөнгөтэй бөгөөд энэ нь нийт ББСБ-ын активын 52.3 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 134,748,694.6 мянган төгрөг буюу 48.2 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 95,847,102.5 мянган төгрөг буюу 43.2 хувийг тус тус эзэлж байна.

Гадаад валютын арилжаа дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 50 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 15.3 хувийг, тэдгээрийн актив нийт ББСБ-ын активын 2.0

хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 3.6 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 3.9 хувийг тус тус эзэлж байна. Гадаад валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг харуулвал дараах байдалтай байна.

		/Хүснэгт 7/		
№	Үндсэн үзүүлэлтүүд	2013 оны II улирал	2014 оны II улирал	Өсөлт /+/, бууралт /-/
	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагааг эрхэлж буй ББСБ-ын тоо	39	50	11
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	<i>16.7%</i>	<i>15.3%</i>	<i>28.2%</i>
A	Нийт актив /мянган төгрөгөөр/	8,029,948.0	10,034,793.6	2,004,845.6
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	<i>2.6%</i>	<i>2.3%</i>	<i>25.0%</i>
B	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	7,895,104.2	9,956,750.1	2,061,645.9
	<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>	<i>4.0%</i>	<i>3.7%</i>	<i>26.1%</i>
B	Нийт дүрмийн сан /мянган төгрөгөөр/	6,678,692.4	8,339,242.4	1,660,550.0
	<i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i>	<i>4.2%</i>	<i>3.9%</i>	<i>24.9%</i>

## ГУРАВ. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 3.1 Активын бүтэц, өөрчлөлт:


Тайлант жилд нийт ББСБ-уудын активын бүтэц өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дараах байдалтай байна.

		/Хүснэгт 8/					
№	ХӨРӨНГӨ	2013.6.30		2014.6.30		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь %	Дүн /мян.төг/	Хувь %	Дүн /мян.төг/	Хувь %
A	Эргэлтийн хөрөнгө	297,169,765.8	96.6	427,107,534.3	96.3	129,937,768.5	43.7
1	Мөнгөн хөрөнгө	83,203,677.8	27.0	126,909,554.4	28.6	43,705,876.6	53.0
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	9,359,030.1	3.0	10,798,192.1	2.4	1,439,162.0	15.0
3	Нийт зээл	188,120,936.3	61.1	270,357,033.0	61.0	82,236,096.7	43.7
	(Зээлийн эрсдлийн сан)	5,127,631.1	1.7	10,669,849.9	2.4	5,542,218.9	107.8
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	1,317.3	0.1	6,394.3	0.0	5,077.0	385.5
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	-	-	-	-	-	-
5	Нийт факторингийн тооцооны авлага	842,431.9	0.3	81,800.0	0.0	(760,631.9)	(90.3)
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	-	0.0	1,500.0	0.0	1,500.00	-
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	835,502.0	0.3	1,310,061.0	0.3	474,559.1	56.8
7	Бусад хөрөнгө	19,934,501.4	6.5	28,315,849.4	6.4	8,381,348.0	42.0
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн авлага	-	0.0	0.0	0.0	-	-
B	Эргэлтийн бус хөрөнгө	10,566,449.6	3.4	16,423,421.2	3.7	5,856,971.6	55.7
9	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	10,566,449.6	3.4	16,423,421.2	3.7	5,856,971.6	55.7
	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	13,837,284.1	4.5	20,592,292.8	4.6	6,755,008.7	49.3
	(Хуримтлагдсан элэгдэл)	3,270,834.6	1.0	4,168,871.6	0.9	898,037.0	27.5
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>307,736,217.0</b>	<b>100.0</b>	<b>443,530,955.5</b>	<b>100.0</b>	<b>135,794,738.5</b>	<b>44.1</b>

2014 оны хоёрдугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 326 ББСБ нь 443,530,955.5 мянган төгрөгийн актив хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа ба

активын өсөлт нь өмнөх оны мөн үеэс 135,794,738.5 мянган төгрөгөөр буюу 44.1 хувиар өссөн байна.

Активын өсөлтийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна. /график 3/



Тайлант хугацаанд нийт активын 96.3 хувь нь эргэлтийн хөрөнгө, 3.7 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байх ба активын голлох үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна. /График 4/



### 3.2 Зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 9/

№	Ангилал	2013.6.30		2014.6.30		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь %	Дүн /мян.төг/	Хувь %	Дүн /мян.төг/	Хувь %
1	Хэвийн	74,134,797.8	92.6	211,434,713.7	78.2	137,299,915.9	185.2
2	Хугацаа хэтэрсэн	6,827,944.9	3.6	15,681,813.7	5.8	8,853,868.8	129.7
3	Чанаргүй зээл. Үүнээс	7,158,193.7	3.8	13,361,779.4	5.0	6,203,585.7	86.1
	Хэвийн бус	1,916,206.2	1.0	3,841,551.0	1.4	1,925,344.7	100.0
	Эргэлзээтэй	1,933,264.8	1.0	3,982,837.9	1.4	2,049,573.1	105.2
	Муу	3,308,722.7	1.8	5,537,390.5	2.0	2,228,667.8	66.7
	(Зээлийн эрсдлийн сан)	5,127,631.0	2.7	10,669,849.9	4.0	5,542,218.9	107.8
	Нийт зээл	188,120,936.3	100.0	270,357,033.0	100.0	82,236,096.7	43.7
	Үүнээс: Гадаад валютаар олгосон зээл	100,000,000.0	53.2	29,878,726.2	11.1	-70,121,273.8	70.1

2014 оны хоёрдугаар улирлын байдлаарх зээлийн үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт зээлийн хэмжээ 82,236,096.7 мянган төгрөгөөр буюу 43.7 хувиар нэмэгдсэн байх ба нийт зээлийн багцад эзлэх хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн эзлэх хувь 11.9 хувь буюу 32,089,248.3 мянган төгрөг байна. Зээлийн ангилал дахь чанаргүй зээлийн эзлэх хувь 7.4-ээс 11.9 хувьд хүрч өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацааны нийт зээлийн үлдэгдлийн 11.1 хувь буюу 29,878,726.2 мянган төгрөгийн зээлийг валютаар олгосон зээлийн үлдэгдэл эзэлж байгаа /41 ББСБ-д/ бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.3 дахин буурсан үзүүлэлттэй байна.

ББСБ-уудын нийт зээлийн багцын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна. /График 5/



Тайлант хугацаанд 274 ББСБ нь Хорооноос банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа ба нийт 270,357,033.0 мянган төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.7 хувь нь буюу 15,378,930.3 мянган төгрөг нь чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл байна.

**3.3 Зээлийн хүү:**


Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын зээлийн сарын хамгийн дээд хүү 10.0 хувь, хамгийн бага хүү 0.5 хувь байна.

ББСБ-уудын зээлийн сарын дундаж дээд хүү 4.2 хувь, зээлийн дундаж доод хүү 2.4 хувь буюу нийт ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү 3.3 хувьтай байна.

ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулбал дараах байдалтай байна.

/График 6/





**3.4 Активын бусад үзүүлэлтийн талаар:**

Богино хугацаат хөрөнгө оруулалтын /цэврээр/ дансны үлдэгдэлд 10,798,192.1 мянган төгрөг байх ба үүний 0.6 хувь нь буюу 61,104.6 мянган төгрөг нь арилжааны үнэт цаас, 99.2 хувь нь буюу 10,761,349.4 мянган төгрөг нь хөрөнгө оруулалтын үнэт цаас тус тус эзэлж байна.

/Хүснэгт 10/

№	Богино хугацаат хөрөнгө оруулалтын төрөл	Хэмжээ /мянган төгрөг/	Богино хугацаат хөрөнгө оруулалтад эзлэх хувь
1	Арилжааны үнэт цаас	61,104.6	0.6%
2	Хөрөнгө оруулалтын үнэт цаас	10,761,349.4	99.2%
3	Эрсдэлийн сан	/24,261.9/	/0.2%/
	Нийт	10,798,192.1	100.0%

Факторингийн тооцооны авлагын 63.3 хувь нь хэвийн, 36.7 хувь нь хугацаа хэтэрсэн авлагад ангилагдан 1,500.0 мянган төгрөгийн эрсдэлийн сан үүсгэсэн байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 326 ББСБ-д 16,423,421.2 мянган төгрөгийн үндсэн ба биет бус хөрөнгө /цэврээр/ бүртгэгдэн ба тэдгээрт 4,168,871.6 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэн тооцон нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

2013 оны 01 дүгээр улирлаас эхлэн ББСБ-аас ирүүлж буй зохистой харьцааны тайланд шинээр нэмж тухайн улиралд олгосон зээл, эргэн төлөлтийн талаарх судалгаа, мөн оны 02 дугаар улирлын тайланд гадаадын даатгалын байгууллагад даатгагдсан эсэх талаарх судалгаануудыг авч эхэлсэн.

Дээрх олгосон зээл, эргэн төлөлтийн талаарх судалгаанд зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг нийт 274 ББСБ-аас 209 ББСБ нь буюу 76.3 хувь нь хамрагдсан бөгөөд судалгаанд хамрагдсан ББСБ-уудад тайлант хугацаанд 179,003.8 сая төгрөгийн зээл олгож, 137,458.6 сая төгрөгийн зээл эргэн төлөгдсөн байна.

Харин тайлант хугацаанд тайлан ирүүлбэл зохих нийт 326 ББСБ-аас 323 ББСБ тайлангаа ирүүлсний дотор гадаадын даатгалын байгууллагад даатгагдсан ББСБ байхгүй байна.

**ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ**

2014 оны тайлант хугацаанд ББСБ-уудын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 11/

№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2013.6.30		2014.6.30		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь %	Дүн /мян.төг/	Хувь %	Дүн /мян.төг/	Хувь %

A	Өр төлбөр	92,967,283.2	30.2	154,860,076.9	34.9	61,892,793.7	66.7
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	17,852,497.0	5.8	24,333,744.82	5.5	6,481,247.8	36.3
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	63,522,781.9	20.6	113,733,652.5	25.6	50,210,870.6	79.1
3	Бусад эх үүсвэр	1,656,119.6	0.5	2,509,963.5	0.6	853,843.9	51.6
	Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	-	0.0	214,027.2	0.0	214,027.2	-
	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	1,656,119.6	0.5	2,295,936.4	0.5	639,816.8	38.7
	Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	-	-	-	-	-	-
	Факторингийн үйлчилгээний өглөг	-	-	-	-	-	-
	Гадаад валютын арилжааны эх үүсвэр	-	-	-	-	-	-
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	376,832.5	0.1	1,757,000.0	0.4	1,380,167.5	366.1
5	Төслийн зээлийн санхүүжилт	9,559,052.2	3.1	12,525,716.0	2.8	2,966,663.8	31.0
	Бусад өр төлбөр	16,054,208.2	5.2	9,205,369.5	2.1	-6,848,838.7	-42.9
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	2,545,833.2	0.8	3,417,494.9	0.8	871,661.7	34.3
7	Бусад пассив	13,506,723.8	4.4	5,787,874.6	1.3	-7,718,849.2	57.0
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	1,651.3	-	-	-	-1,651.3	-100.0
	Нийт өр төлбөр	109,021,491.4	35.4	164,065,446.4	37.0	55,043,955.0	50.5
B	Эзэмшигчдийн өмч	198,714,723.9	64.6	279,465,509.1	63.0	80,750,785.2	40.7
9	Хувьцаат капитал	160,984,853.6	52.3	221,865,334.5	50.0	60,880,480.9	37.8
10	Бусад өмч	6,573,384.5	2.1	8,248,645.7	1.9	1,675,261.2	25.5
11	Сангууд	187,258.4	0.1	306,815.4	0.1	119,557.0	63.9
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	29,146,594.2	9.5	47,254,600.9	10.7	18,108,006.7	62.1
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	1,822,633.2	0.6	1,790,112.8	0.4	-32,520.4	-1.8
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	<b>307,736,217.0</b>	<b>100.0</b>	<b>443,530,955.5</b>	<b>100.0</b>	<b>135,794,738.5</b>	<b>44.1</b>

2014 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт эх үүсвэрийн 37.0 хувийг нийт өр төлбөр, 63.0 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 50.5 хувиар, эзэмшигчдийн өмч 40.7 хувиар тус тус өссөн байна.


ББСБ-уудын системийн нийт пассивын голлох үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

График 7/




Эх үүсвэрт эзлэх нийт өр төлбөр өссөн гол шалтгаан нь ББСБ-уудын дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл 79.0 хувиар, төслийн зээлийн санхүүжилтийн хэмжээ өмнөх оноос 31.0 хувиар өссөнтэй холбоотой.

/График 8/



/График 9/



2014 оны хоёрдугаар улирлын байдлаар итгэлцлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй 23 ББСБ байгаагаас нэр бүхий 18 ББСБ нь итгэлцлээр 24,333,744.8 мянган төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлсэн байх ба эдгээр нь нийт ББСБ-ын 5.5 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 39.5 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 28.3 хувийг тус тус эзэлж байна.

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 6 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагаас 2014 оны хоёрдугаар улирлын тайлант хугацаанд тэдгээрт 2,618,908.8 мянган төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг бүртгэлтэй байна.

Тайлант хугацаанд Хорооны зөвшөөрөлтэйгөөр 3 ББСБ нийт 1,281,000.0 мянган төгрөгийн хаалттай өрийн бичгийг гаргасан байх ба 7 ББСБ-д 1,715,769.6 мянган төгрөгийн хоёрдогч өглөг бүртгэгдсэн байна.

### ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

ББСБ-уудын 2014 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт орлого өмнөх оны мөн үеэс 88.4 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

/Хүснэгт 12/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2013.6.30		2014.6.30		Өөрчлөлт	
		Дүн /мянган төгрөг/	Хувь %	Дүн /мянган төгрөг/	Хувь %	Дүн /мянган төгрөг/	Хувь %
1	ХҮҮГИЙН ОРЛОГО	29,332,018.0	77.3	41,486,376.9	65.3	12,154,358.9	41.6
	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	28,543,429.8	75.2	40,133,821.2	63.1	11,590,391.5	40.7
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	549,323.1	1.4	1,165,477.5	1.8	616,154.4	112.2
	Үнэт цаасны хүүгийн орлого	0.0	0.0	24,996.6	0.0	24,996.6	-
	Бусад хүүгийн орлого	239,265.2	0.6	187,078.3	0.3	-52,186.9	-21.8
2	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	8,039,990.3	21.2	21,342,405.1	33.6	13,302,414.8	166.3
3	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	565,089.0	1.5	689,633.4	1.1	124,544.4	22.0
4	ЕРДИЙН БУС ОРЛОГО	28,510.0	0.1	45,953.8	0.1	17,443.8	61.1
	НИЙТ ОРЛОГО	37,965,607.3	100.0	63,564,369.2	100.0	25,598,761.9	67.4

Тайлант хугацааны нийт орлогын 65.3 хувийг хүүгийн орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн орлогын дүнтэй харьцуулахад 41.6 хувиар өссөн/, 33.6 хувийг хүүгийн бус орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн бус орлогын дүнтэй харьцуулахад 2.6 дахин өссөн/ эзэлж байна.

Хүүгийн бус орлого өмнөх оны мөн үеэс 2.6 дахин өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

/Хүснэгт 13/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2013.6.30		2014.6.30		Өөрчлөлт	
		Дүн /мянган төгрөг/	Хувь %	Дүн /мянган төгрөг/	Хувь %	Дүн /мянган төгрөг/	Хувь %
1	Арилжааны орлого	1,632,588.3	20.3	2,117,020.0	9.9	484,431.7	29.6
1.1	Гадаад валютын арилжааны орлого	1,632,309.8	20.3	2,117,010.0	9.9	484,700.2	29.7
1.2	Үнэт цаасны арилжааны орлого	278.5	0.0	-	-	-278.5	100.0
2	Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	3,647,594.8	45.4	15,583,404.7	73.0	11,935,809.9	330.6
2.1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	3,392,335.5	42.2	14,389,529.6	67.4	10,997,194.1	323.5
2.2	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	255,259.3	3.2	1,193,875.1	5.6	938,615.8	367.6

3	Санхүүгийн үйлчилгээний орлого	2,759,807.2	34.3	3,641,980.4	17.1	882,173.2	32.0
3.1	Санхүүгийн түрээсийн орлого	197.0	0.0	5,371.4	0.0	5,174.4	26.3 дахин
3.2	Итгэлцлийн үйлчилгээний орлого	-	-	566.8	0.0	566.8	-
3.3	Мөнгөн гуйвуулгын орлого	331,663.0	4.1	436,977.2	2.0	105,314.2	31.8
3.4	Картын үйлчилгээний орлого	-	-	870.0	0.0	870.0	-
3.5	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	363,655.2	4.5	346,167.1	1.6	-17,488.1	-4.8
3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	1,822,902.8	22.7	2,596,667.6	12.2	773,764.8	42.5
3.7	Бусад	241,389.3	3.0	255,360.3	1.2	13,971.0	5.8
	<b>ХҮҮГИЙН БУС ОРЛОГО НИЙТ</b>	<b>8,039,990.3</b>	<b>100.0</b>	<b>21,342,405.1</b>	<b>100.0</b>	<b>13,302,414.7</b>	<b>165.5</b>

2013 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт хүүгийн бус орлогын 20.3 хувийг гадаад валютын арилжааны орлого, 45.4 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 34.3 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байсан бол 2014 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт хүүгийн бус орлогын 9.9 хувийг гадаад валютын арилжааны орлого, 73.0 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 17.1 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байна.

Нийт зардлын бүтэц дараах байдалтай байна.

/Хүснэгт 14/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2013.6.30		2014.6.30		Өөрчлөлт	
		Дүн /мянган төгрөг/	Хувь %	Дүн /мянган төгрөг/	Хувь %	Дүн /мянган төгрөг/	Хувь %
1	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	3,975,634.90	15.9	6,452,660.13	13.6	2,477,025.23	62.5
2	ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	17,441,152.10	69.8	33,245,973.23	69.9	15,804,821.13	90.8
3	БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ	1,574,192.60	6.3	5,272,815.69	11.1	3,698,623.09	2.3 дахин
4	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	429,050.30	1.7	565,192.48	1.2	136,142.18	31.7
5	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	2,516.10	0.0	5,112.91	0.0	2,596.81	1.3 дахин
6	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	1,579,822.70	6.3	2,049,797.24	4.3	469,974.54	29.7
	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>25,002,368.70</b>	<b>100.0</b>	<b>47 591 551,68</b>	<b>100.0</b>	<b>22,589,182.98</b>	<b>90.4</b>

Тайлант хугацаанд нийт зардал өмнөх оны мөн үеэс 90.4 хувиар өссөнөөс хүүгийн зардал 62.5 хувиар, хүүгийн бус зардал 90.8 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 2.3 дахин, үндсэн бус үйл ажиллагааны зардал 31.7 хувиар, орлогын татварын зардал 29.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.


2014 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт орлого өмнөх оны мөн үеэс 68.4 хувиар, нийт зардал 90.4 хувиар өссөн байна.

Тайлант хугацаанд нийт 15,975,763.1 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 23.1 хувиар өссөн байна.

/Хүснэгт 15/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2013.6.30	2014.6.30	Өөрчлөлт
		Дүн /мянган төгрөг/	Дүн /мянган төгрөг/	Дүн /мянган төгрөг/
1	НИЙТ ОРЛОГО	37,965,607.3	63,564,369.2	25,598,761.9
2	НИЙТ ЗАРДАЛ	25,002,368.6	47,591,551.7	22,589,183.1
	ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ	12,963,238.7	15,972,817.6	3,009,578.9

ББСБ-уудын нийт орлого, зардлын үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна. /График 10/



**ЗУРГАА. БҮЛГИЙН САНХҮҮГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Нийт ББСБ-уудыг активын хэмжээгээр нь 400,000.0 мянган төгрөг хүртэл активтай, 400,000.0 мянган төгрөгөөс 1.0 тэрбум төгрөг хүртэл активтай, 1.0 тэрбум төгрөгөөс 5.0 тэрбум төгрөг хүртэлх активтай, 5.0 тэрбум төгрөг ба түүнээс дээш төгрөгийн активтай ББСБ гэсэн 4 бүлэгт хуваан тооцов.

2014 оны хоёрдугаар улирлын байдлаарх бүлгүүдийн бүтэц дараах байдалтай байна:

/Хүснэгт 16/

№	Бүлэг	Бүлэгт хамаарах ББСБ-ын тоо	Бүлгийн нийт актив		Нэмэлт мэдээлэл
			Актив /мянган төгрөг/	Нийт активт эзлэх хэмжээ /хувь/	
1	Бүлэг 01	18	231,069,304.70	52.1%	5.0 тэрбум төгрөгнөөс дээш активтай
2	Бүлэг 02	56	110,230,074.40	24.9%	1.0 тэрбумаас 5.0 тэрбум төгрөг хүртэлх активтай
3	Бүлэг 03	160	336,004,216.19	75.8%	400,000.0 мянган төгрөгөөс 1.0 тэрбум төгрөг хүртэл хэмжээний активтай
4	Бүлэг 04	92	13,312,491.00	3.0%	400,000.0 мянган төгрөг хүртэл хэмжээний активтай
<b>НИЙТ</b>		<b>326</b>	<b>443,530,955.49</b>	<b>100.0</b>	

2013 оны жилийн эцсийн байдлаарх бүлгүүдийн тайлант үеийн ашиг дараах байдалтай байна. Үүнд:

/Хүснэгт 17/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Нийт актив /мянган төгрөг/	Дүрмийн сан /мянган төгрөг/	Тайлант хугацааны цэвэр ашиг /мянган төгрөг/	Салбарын нийт татварын дараах цэвэр ашигт эзлэх хувь
1	Бүлэг 01	231,069,304.70	66,419,952.20	7,546,224.04	47.2%
2	Бүлэг 02	110,230,074.40	70,119,596.20	5,614,369.10	35.1%
3	Бүлэг 03	336,004,216.19	238,847,835.86	13,372,567.32	83.7%
4	Бүлэг 04	13,312,491.00	13,282,857.40	-668,395.30	-4.2%
	<b>НИЙТ</b>	<b>443,530,955.49</b>	<b>221,865,334.46</b>	<b>15,972,817.56</b>	<b>100.0%</b>

Бүлгүүдийн актив, ашгийн үзүүлэлтүүдийг харьцуулан харахад “Бүлэг 01”-д хамаарах 18 ББСБ нь нийт ББСБ-уудын 5.5 хувийг эзэлж байгаа боловч эдгээр компаниудад нийт ББСБ-уудын актив хөрөнгийн 52.1 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгийн 29.9 хувь, татварын дараах цэвэр ашгийн 47.2 хувийг тус тус эзэлж байгаа нь салбартаа голлох байр суурийг эзэлж байна.

### ДОЛОО. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ББСБ-ын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

- нийт өөрийн хөрөнгө 279,473,289.20 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 309,161,110.62 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын хувьд 62.07% хувь, өөрийн хөрөнгийн хувьд 90.53% хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд 88.98% хувь;

- валютын дансны цэвэр зөрүү 11,634,294.87 мянган төгрөг, тухайн валютаарх өөрийн хөрөнгө 279,252,392.47 мянган төгрөг байгаагаас нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 4.17% хувь;

- итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 24,333,744.82 мянган төгрөг, өөрийн хөрөнгө 278,035,470.35 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн харьцаа 8.75% хувь;

- нийт зээлийн өрийн үлдэгдэл 270,357,033.0 мянган төгрөг, үүнээс чанаргүй зээл 15,378,930.3 мянган төгрөг байгаагаас нийт зээл чанаргүй зээлийн харьцаа 5.7 хувь;

- нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 8,165,888.9 мянган төгрөг, нийт актив 442,109,196.4 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.9% хувь байгаа нь зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.

Харин активын эрсдэлийн санг 10,607,424.91 мянган төгрөгөөр байгуулбал зохихоос 432,454.50 мянган төгрөгөөр илүү буюу нийт 11,039,879.41 мянган төгрөгөөр байгуулсан байна.<sup>1</sup>

### ДОЛОО. ДҮГНЭЛТ

- 2014 оны хоёрдугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан ирүүлбэл зохих нийт 326 ББСБ-аас 323 ББСБ буюу 99.1 хувь нь тайлангаа ирүүлсэн ба 10 ББСБ буюу 3.1 хувь нь эхлэлтийн санхүүгийн тайлангийн дүнгээр хамрагдсан байна.
- ББСБ-уудын голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт актив 135,794,738.5 мянган төгрөгөөр буюу 44.1 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 82,236,096.7 мянган төгрөг буюу 43.7 хувь, эзэмшигчдийн өмч 80,750,785.2 мянган

<sup>1</sup>Энэхүү тоон үзүүлэлтийг гаргахдаа тухайн ББСБ-уудын ТОП20 зээлдэгчийн мэдээлэлд тулгуурлан гаргасан болно.

төгрөг буюу 40,7 хувь, нийт дүрмийн сан 60,880,480.9 мянган төгрөг буюу 37,8 хувиар тус тус өссөн.

3. ББСБ-уудын нийт актив 2014 оны хоёрдугаар улирлын байдлаар 443,530,955.5 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт активтай харьцуулахад /банкны салбарын нийт актив 21,419,492,409.9 мянган төгрөг/ 1.9 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 270,357,033.0 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт зээлтэй харьцуулахад /банкны салбарын нийт зээл 12,402,907,377.1 мянган төгрөг/ 2.2 хувь, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 15,378,930.3 мянган төгрөг байгаа нь банкны салбарын чанаргүй зээлтэй харьцуулахад /банкны салбарын чанаргүй зээл 565,310,630.3 мянган төгрөг/ 2.7 хувь, нийт дүрмийн сан 221,865,334.5 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт дүрмийн сантай харьцуулахад /банкны салбарын нийт дүрмийн сан 378,218,447.4 мянган төгрөг/ 58.7 хувьтай тус тус тэнцэж байна.
4. Зээлийн мэдээллийн тухай хууль 2011 оны 10 дугаар 20-ны өдөр батлагдан гарснаар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хуулиар зөвшөөрсөн байгууллага зээлийн мэдээллийн сантай байхаар хуульчилсны дагуу тайлант улиралд нийт 140 ББСБ Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан, зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглаж байгаа нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх 274 ББСБ-ын 51.1 хувийг эзэлж байна.
5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Хорооны 2009 оны 253 дугаар тогтоолоор баталсан “Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”-д заасны дагуу нийт ББСБ-ын 70.9 хувь буюу 231 ББСБ нь “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод журам”-ыг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, 94.2 хувь буюу 307 ББСБ дээрх хуулийн хэрэгжилтийг хариуцах, байнгын хяналт тавих үүрэг бүхий ажилтныг томилон ажиллуулж байна.
6. 2014 онд Хороонд зохицуулалт үйлчилгээний хөлс төвлөрүүлбэл зохих нийт 263 ББСБ-ын 259,512.0 мянган төгрөгийн хөлс төлөгдөхөөс 2014 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 238 ББСБ-ын 236,417.0 мянган төгрөгийг Хорооны дансанд төвлөрүүлсэн нь 90.5 хувьтай байна.
7. Нийт 263 ББСБ нь Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хөндлөнгийн аудитаар баталгаажуулах хуулийн хариуцлагатайгаас 96.2 хувь буюу 253 ББСБ санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулан Хороонд ирүүлсэн.
8. Бичил санхүүгийн хөгжлийн сангаас дамжуулан зээлдүүлэх сонгон шалгаруулалтад 24 ББСБ-ын санхүүгийн үзүүлэлтүүдийн талаарх судалгаа хийгдсэн бөгөөд 2014 оны нэгдүгээр улирлын байдлаар 12,525,716.0 мянган төгрөгийн төслийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байна.

### **НАЙМ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛБЭЛ ЗОХИХ АРГА ХЭМЖЭЭ**

Тус газраас 2014 онд дараах асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байна.

1. ББСБ-уудаас хүлээн авах санхүүгийн тайлан мэдээ, мэдээллийг цуглуулах мэдээллийн цахим сан, нэгдсэн сүлжээг сайжруулах;
2. Тайлант хугацаанд ирүүлвэл зохих тайлан, мэдээг ББСБ-даас бүрэн авч, нэгтгэлд бүрэн хамруулах;
3. УИХ-аас 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдөр батлан гаргасан Зээлийн мэдээллийн тухай хуулийн 9.1.7-д “Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах гэрээг байгуулж,



- мэдээлэл солилцох үүрэг хүлээх” гэсэн заалтын дагуу ББСБ-уудыг Монголбанкны Зээлийн мэдээллийн санд бүрэн хамруулах;
4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Хорооны 2009 оны 253 дугаар тогтоолоор баталсан “Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”-ын 7.1-д Мэдээлэх үүрэгтэй этгээд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд дотоод хяналтын хөтөлбөрийг баталж мөрдөх бөгөөд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод журам”-ын хэрэгжилтийг хариуцах, байнгын хяналт тавих үүрэг бүхий ажилтныг томилж ажиллуулна... гэсэн заалтын дагуу ББСБ-уудын холбогдох хууль, журмын хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах;
  5. Зээл, зээлтэй адилтган тооцох активыг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу ангилж хэвшүүлэх;
  6. Үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, санхүү, төлбөрийн чадварыг тогтворжуулах, хууль, журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор ББСБ-уудын удирдлага, ажилтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулах, сургалтын үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй.

## **БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР**